БАТЛАВ: ГУРВАНТЭС СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА.....Э.АЛДАРБАЯР

“ДАЛАНЗАДГАД – ГУРВАНТЭС-ДАЛАНЗАДГАД ЧИГЛЭЛД ЭМНЭЛЭГИЙН ЯАРАЛТАЙ ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОРТОЙ НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭХ” АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

№	Захиалгч байгууллага	Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Засаг даргын Тамгын газар
1	Зориулалт	“Даланзадгад – Гурвантэс - Даланзадгад” чиглэлд түргэн тусламжийн нөхөн олговортой нислэг гүйцэтгэх
2	Санхүүжилт	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас түргэн тусламжийн нөхөн олговортой нислэгийн гүйцэтгэлийг долоо хоногт 2 удаа байхаар үндэслэн санхүүжүүлнэ.
3	Байршил	Өмнөговь аймаг, Гурван тэс сум
4	Ерөнхий шаардлага	- Арилжааны агаарын тээвэрлэлт эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх. -Нислэгийн үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн маягт, багтаамжийн талаарх мэдээлэл, сумдын шороон зурвас дээр нислэг гүйцэтгэх чадамжтай байх -Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн сумдуудад нислэг гүйцэтгэх түр зурвасуудын талаарх мэдээлэл -Түргэн тусламжийн нөхөн олговортой нислэгийн чиглэлийн давтамжийг тодорхойлсон цагийн хуваарь, -Нөхөн олговортой нислэг үйлдэх чиглэлд гаргасан техник, эдийн засгийн үндэслэл, нислэгийн зардлыг үнэн бодитой тооцоолсон байх; -Зорчигчдын мөрдөх тарифын үнийн саналыг ТББ-т заасны дагуу ирүүлэх;

		- Эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ авах шаардлагатай иргэнийг дараалал харгалзахгүй тээвэрлэх нөхцөлийг хангасан мэдэгдэл ирүүлэх
5	Нислэгийн төрөл	Бага оврын агаарын хөлгөөр (9 хүртэл суудалтай) эмнэлгийн яаралтай тусламжийн нислэг үйлдэх эрхтэй байх.
6	Техникийн бэлэн байдал	Даланзадгад, Гурвантэс чиглэлийн шороон болон сайжруулсан зурваст буух техникийн боломжтой агаарын хөлөгтэй байх.
7	Эмнэлгийн тоноглол	Өвчтөн тээвэрлэх дамнуурга (stretcher) суурилуулах боломжтой, хүчилтөрөгчийн аппарат болон эмнэлгийн тоног төхөөрөмж ажиллах хүчдэлийн эх үүсвэртэй байх.
8	Даатгалын баталгаа	Зорчигч (өвчтөн), эмнэлгийн баг болон гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалд бүрэн хамрагдсан байх.
9	Нөхөн олговрын тооцоолол	Нислэгийн бодит зардалд үндэслэсэн нөхөн олговрын тарифыг үндэслэлтэйгээр ирүүлэх.